

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2015 оны 01 дугаар сарын 16-ны
өдрийн 15 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

**Оршуулах талбайн нөөцгүй болсон оршуулгын
газрын байршил, талбайн хэмжээ**

д/д	Оршуулгын газрын нэрс	Байршил	Талбайн хэмжээ /га/
1	Самбалхүндэвийн оршуулгын газар /Далан давхар/	ЧД, 12-р хороо	73.9
2	Цагаан давааны оршуулгын газар	БЗД, 22-р хороо	51.2
3	Буянт-Ухаагийн оршуулгын газар /Нисэх/	ХУД, 16-р хороо	3.7
4	Мянган лантын оршуулгын газар	БЗД, 20-р хороо, Гачууртын Баяндөхөм	30.6
5	Оросын оршуулгын газар	БЗД, 5-р хороо	1.9
6	Японы оршуулгын газар	СБД, 17-р хороо	15.2



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2015 оны 01 сарын 16 өдөр

Дугаар 15

Улаанбаатар хот

Оршуулгын газрын байршил, хэмжээг тогтоож,
зарим оршуулгын газрыг хаах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь заалтыг үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт оршуулгын зан үйл үйлдэх газрын байршил, талбайн хэмжээг 1 дүгээр хавсралтаар баталж, хамгаалалтын бүсийг батлагдсан хил хязгаараас эргэн тойронд 300 метрт тогтоосугай.


2. Оршуулах талбайн нөөцгүй болсон оршуулгын газрын байршил, талбайн хэмжээг 2 дугаар хавсралтаар баталж, үйл ажиллагааг нь хааж, хамгаалалтын бүсийг одоо байгаа хил хязгаараар тогтоосугай.

3. 1, 2 дугаар хавсралтад заасан оршуулгын газруудын хил хязгаарын солбицлын цэгийг 3 дугаар хавсралтаар баталсугай.

4. Оршуулгын газруудын хил хязгаар, хамгаалалтын бүсийн хил хязгаарын солбицлын цэгийг нийслэлийн газрын мэдээллийн санд бүртгүүлэх, хамгаалалтын зурвасыг тэмдэгжүүлэх, одоо ажиллаж байгаа болон хаагдсан оршуулгын газруудыг арчилж хамгаалах ажлыг зохион байгуулж, дээрх үйл ажиллагаатай холбогдон гарах зардлыг жил бүрийн орон нутгийн төсөвт тусгуулж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /Э.Бат-Үүл/-д үүрэг болгосугай.

5. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 94 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ХҮХ-5
2015.01.26.
ДАРГА



Д.БАТТУЛГА

1110100099